Хуудас 1 (Нүүр)

Олон улсын зуслангуудын холбоо
Жилийн эцсийн тайлан 2015
Хуудас 2
Гарчиг
Ерөнхийлөгчийн мэндчилгээ 3
Гишүүнчлэл 4
Элч нар 7
ICDC буюу Олон улсын зуслангуудын захирлуудын сургалт 8
Судалгаа шинжилгээ 9
Шагнал, хөтөлбөр, Холбооны ерөнхийлөгч, Гүйцэтгэх Захирлуудын хурал 10
АНДЗХ, АНДЗХ-ы Их хурал - 11
Санхүүгийн тайлан 12
Засаглал 14
ОУЗХ-ны Удирдах зөвлөл 15

Олон Улсын Зуслангуудын Холбоо нь өөрсдийн хүсэл сонирхол, мэдлэг чадвар, зуслангийн хөгжилд оруулсан хувь нэмэр, туршлагаа бусадтайгаа хуваалцах сонирхлоор нэгдсэн олон улсын зуслангийн мэргэжилтнүүдийн холбоо юм.

Энэ нь “гадна орчны сургалтуудыг нэгтгэн хөгжүүлэх” замаар өөрчлөлт шинэчлэлтийг бий болгоно гэсэн итгэл үнэмшилд суурилдаг.

Зохион байгуулалтай зуслангийн үйл ажиллагаагаар дамжуулан олон улсын харилцан ойлголцлыг хөхүүлэн дэмжихийг хүссэн хүн бүрийг Олон улсын зуслангуудын холбоо халуун дотноор хүлээн авдаг.

ОУЗХ-ны зорилго:

- Хувь хүмүүс, зуслангуудын хооронд мэдээ мэдээлэл, гадна орчны хөтөлбөрүүдийн туршлага болон өөр өөр орнуудад хэрэгжүүлдэг зохион байгуулалтын арга хэлбэрээ солилцох үйл явцад дэмжлэг үзүүлэх,
- Хоёр талын болон олон талын туршлагаа харилцан солилцохыг хөхүүлэн дэмжих,
- Зохион байгуулалттай зуслан болон гадна орчны хөтөлбөрөөр дамжуулан дэлхий ертөнц, олон улс, манлайллын талаар ойлголт авч, байгаль экологид ээлтэй үйл ажиллагаа явуулахад нь түлхэц, урам зориг өгөх,
- Бүсийн болон үндэсний зуслангуудын холбоодын зохион байгуулалт, үйл ажиллагааг дэмжих

Хуудас 3

Ерөнхийлөгчийн мэндчилгээ

Өнгөрсөн жилийн хувьд ОУЗХ -ны зүгээс дэлхийн өнцөг булан бүрт явуулдаг үйл ажиллагаагаа эрчимжүүлэн, хөгжүүлэх ажлаа амжилттай үргэлжүүлж ирлээ. Хүүхэд залуусыг хөгжүүлэх болон зуслангуудад чиглэсэн арга хэмжээг хувь хүн зөвлөхүүдээс эхлээд бүсийн холбоод, хороод, үндэсний байгууллага, хурлаас эхлээд олон улсын их хурал хүртэл шат шатанд хэрэгжүүллээ.

Би энэхүү мэндчилгээгээ жилийн эцсийн тайлангийн сүүл хэсэгт онцгойлон анхаарах мэдээллээр эхэлж байна. Өнгөрсөн онд зохион байгуулсан томоохон арга хэмжээнүүдийг

энд дурдах нь зүйтэй юм. Зуслангийн залуу мэргэжилтнүүдийн багаар удирдуулсан Турк улсын Анталя хотод болсон Олон улсын зуслангуудын их хурал нь үнэхээр онцгой, мартагдахааргүй үйл явдал боллоо. Фахретин, Мурат, Осман Гозет нар зуслангийн орчинд хийж бүтээх эрч хүч, урам зоригоор дүүрэн зуслангийн удирдагч нарын л бүтээж чадах тийм гайхамшгийг бий болгохын тулд энэхүү гайхалтай сайн дурын багийг бүрдүүлж чадсан юм.

Олон улсын зуслангуудын холбооны цахим сүлжээ "ICF Connect" – ийг бий болгоход чиглэсэн ОУЗХ-ны Удирдах зөвлөлөөс авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа ч мөн асар их ач холбогдолтой байлаа. Америкийн Зуслангуудын Холбооноос жил бүр зохион байгуулдаг Олон улсын танилцах аялал шиг ОХУ-д болсон олон улсын төлөөлөгч нарт зориулсан сургалт семинар, Хятад дахь зуслангуудын үйл ажиллагаа, соёлыг сурталчлах зорилгоор Бээжин хотод зохион байгуулсан их хурлууд, мөн бусад гишүүн орнуудад зохиогддог үндэсний хурлууд болон ОХУ-д болсон Удирдах зөвлөлийн гишүүдийн уулзалт, хэд хэдэн тивүүдэд зохион байгуулсан Захирлуудын сургалт зэрэг нь ОУЗХ-ны хувьд онцлох үйл явдлууд болсон юм.

Зун бүр, өдөр бүр дэлхийн өнцөг булан бүрт зохион явуулдаг зуслангийн үндсэн үйл ажиллагаануудын хүрээнд байнга давтагддаж байдаг ч дээрх томоохон арга хэмжээнүүдийн дунд анзаарагдалгүй орхигдсон нэг зүйлийг бид энэ жилийн хувьд онцлох нь зүйтэй гэж үзэж байна. ОУЗХ-нд хамааралгүй ч гэсэн зуслангийн удирдах ажилтнууд нь залуучуудын амрах соёлыг 2015 онд өндөр түвшинд гаргаж тавьсан.

Дэлхийн залуустай хамт сурч, ажиллаж, өсч хөгжиж байгаа тэдгээр зуслангийн залуу удирдах ажилтнууд нь 2015 онд төдийгүй ирээдүйд ч үнэлэгдэх зуслангийн салбарын жинхэнэ алдартнууд юм.

Жон Йоргенсен, ОУЗХ- ны Ерөнхийлөгч

Хуудас 4

Гишүүнчлэл

ОУЗХ-ны жинхэнэ гишүүд болон түүний салбаруудын тоо 2014-2015 онд 10%-аар өссөн. ОУЗХ-ы цахим хуудсаар бүртгүүлсэн Гишүүд болон Холбоод, Мексик, Сингапурт болсон Олон улсын зуслангийн захирлуудын сургалтууд:

Гишүүн бус байгууллагууд (үнэ төлбөргүй)	3702
Зуслангийн холбоод	7
Зуслангууд	309
Хувь хүн	194
Байгууллагууд	46

Нийт 2015 Гишүүд ба гишүүн бус байгууллагууд 4258

Гишүүн бус байгууллагууд: 2012 оноос хэрэгжиж эхэлсэн төлбөргүй гишүүн бус байгууллагын статусаар ОУЗХ-аас санал болгож буй энгийн цахим харилцаа холбоог ашиглах эрхтэй болно.

Жинхэнэ гишүүд: Жинхэнэ болон татвартай гишүүнчлэлийн дэд ангиллаар /хувь хүн, зуслан, байгууллага, холбоо/ их хуралд хөнгөлттэй үнээр оролцох, давуу эрхтэйгээр санал өгөх, ажлын албанд өрсөлдөх, гишүүнчлэлийн гэрчилгээ авах зэрэг олон давуу талыг эдлэх боломжтой болно. Зуслангууд, Байгууллагууд, Холбоод нь ОУЗХ-ны цахим хуудас дээр өөрсдийн байгууллагын цахим холбоосыг байршуулдаг ба ОУЗХ – ийн логог өөрсдийн маркетинг/сурталчилгааны ажилд ашиглах, Америкийн зуслангуудын холбоо болон Ази Номхон далайн зуслангуудын холбооноос зохион байгуулах тодорхой арга хэмжээнүүдэд оролцох боломжтой болдог.

Цахим бүртгэл: ОУЗХ- ны цахим хуудас нь шинээр бүртгүүлэх, гишүүнчлэлээ шинэчлэх, салбарын статус хүсэх зэрэг онлайн процессийг хэрэглэхэд илүү хялбар болгож өгсөн. Гишүүнээр элсэх хүмүүс нь Билл Бөүкэрийн Сургалтын Тэтгэлгийн Сан болон ОУЗХ-ы Эрвээхэй Санд хандив өргөх боломжтой.

Зуслангийн холбоодтой ямар харилцаатай талаар: Зуслангийн болон залуусын хөгжлийн удирдагч, манлайлагчдыг дэлхийн зуслангийн байгууллагын хамт олны хүрээлэлд нэгтгэх хүчин чармайлтын хүрээнд хамтын ажиллагааны сүлжээг бий болгох үүднээс ОУЗХ-ны Удирдах Зөвлөл үндэсний болон бүсийн хэмжээний байгууллагуудтай шууд хамтран ажилласаар байна.

Америкийн Зуслангийн Холбооны Боловсролын Түнш болох зорилгоор Америкийн Зуслангуудын Холбоотой (АЗХ) хийсэн түншлэлийн гэрээний хугацааг 2013 оны 2-р сард сунгасан. Үүний үр дүнд ОУЗХ нь өдгөө АЗХ-ны Бизнесийн Түнш болсон ба 2014 оны Олон улсын зуслангийн холбооны их хурал Тасралтгүй Боловсролын Кредит олгоход дэмжлэг авсан байна.

Австралийн зуслангуудын холбоо нь ОУЗХ-тэй түншийн харилцаатай болсны үр дүнд өөрийн холбооны жинхэнэ гишүүддээ ОУЗХ-ны гишүүнчлэлийг олгосоор 4 дахь жилээ үзэж байна.

Харилцан ашигтай хамтын ажиллагаа, түншлэлийн загварыг гаргахад бусад холбоодод туслах зорилготой хэлэлцүүлэг 2016 онд ч үргэлжлэх болно. Уг ажилд хамаарах асуудлын талаар хэлэлцэж, нэрийн хуудас солилцох зорилгоор 2017 онд болох дараачийн Олон улсын Зуслангуудын Их Хуралд Зуслангийн холбооны удирдах ажилтнууд (MAPE: Холбооны ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлуудын хурал) хуран чуулах болно.

Хуудас 5

ОУЗХ-ны гишүүд ба гишүүн бус байгууллагууд – Гишүүн орнууд

Хуудас 6

Олон улсын зуслангийн холбооны цахим сүлжээ (ICF Connect)

ОУЗХ – наас одоо хэрэгжүүлж буй бас нэг төсөл бол ОУЗХ –ы цахим сүлжээ юм. Энэхүү төсөл нь ОУЗХ- ы нийт гишүүд болон гишүүн бус байгууллагуудад цахим уулзалт, хурал зохион байгуулах боломжийг олгох замаар гишүүдэд чиглэсэн үйлчилгээг дэмжин бэхжүүлэх зорилготой. Төсөл хэрэгжсэнээр хэрэглэгчид өөрсдийн хувийн мэдээллээ оруулж, шинэчилж, мэдлэг мэдээллээ хуваалцах, шинэ санаа дэвшүүлэх, сонирхож буй асуудлаараа харилцан хэлэлцэх, гишүүнчлэлээ шинэчлэх, ОУЗХ –ны арга хэмжээнүүдэд бүртгүүлэх боломжтой болно.

ОУЗХ цахим сүлжээ төсөл нь ОУЗХ- д нэгдсэн бусад холбоодод чиглэсэн дэмжлэгийг нэмэгдүүлэх, дэлхийн хэмжээнд мэдээ, мэдээллээ солилцох, арга туршлага судлах, гишүүнчлэл ба гишүүн бус байгууллагуудын хөгжлийг дэмжихэд чухал хөшүүрэг болох юм. Утку Топраксевен, сайн дурынхны багтай хамтран энэхүү гишүүдэд чиглэсэн үйлчилгээг цогцоор нь хөгжүүлж байгаа бөгөөд ирэх жилийн дунд гэхэд энэ ажлаа бүрэн дуусгах болно.

Энгийн хэрэглэгчдэд зориулсан боломжууд

- **Гишүүний мэдээллийн сан:** Цахим мэдээллийн сангаар дамжуулан хувь хүн, холбооны гишүүд, ОУЗХ-ны гишүүн бус байгууллагууд өөрсдийн хувийн болон холбоо барих мэдээлэлээ шинэчилж, сургалт, хөгжлийн хөтөлбөрийн арга хэмжээтэй танилцаж, бусад гишүүдийн үйл ажиллагааг дэмжих боломжтой.

· **Номын сан:** Төрөл бүрийн бичиг баримт, зураг, цахим холбоосууд гэх мэт зуслантай холбоотой бичиг баримтуудын цахим номын сангаар дамжуулан ОУЗХ-ний гишүүд сонгогдсон сэдвийн дагуу мэдээ мэдээлэлтэй танилцаж, мэдлэг туршлагаа хуваалцах боломжтой.

Гишүүдийн хурал: Цахим хурлаар урьдчилан тодорхойлсон сэдэв, ангиллын хүрээнд өөрийн сонирхсон тодорхой чиглэлээр бусад ОУЗХ –ны гишүүтэй хэлэлцүүлэг өрнүүлж, санал бодлоо солилцох боломжийг олгоно.

· **Үйл явдлын хуанли:** Үйл явдлын хуанли нь ОУЗХ-ны гишүүдэд ОУЗХ-аас зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч, бүртгүүлэх боломжийг олгохын зэрэгцээ үйл явдал болох газрын хаяг байршил, огноо, бүртгэлийн хураамж болон бусад оролцогчдын талаарх мэдээллийг өгнө.

Удирдлагын шатны гишүүдэд зориулсан нэмэлт үүрэг

· Гишүүнчлэлийн удирдлага

· Дүн шинжилгээний хяналтын самбар, хувийн хэрэг, уулзалт, хэлэлцээр

2015 онд болсон үйл явдал, арга хэмжээ

· Хөгжлийн ба бета судалгаа

· 2015 оны намар Сочи-д болсон ОУЗХ-ны Удирдах зөвлөлд танилцуулсан илтгэл

· Удирдах зөвлөлийн гишүүдэд ОУЗХ –ны цахим сүлжээ төслийн талаар мэдээлэл хүргэх

Дараачийн үе шатны ажлууд: Бодлого төлөвлөлт, Харилцаа холбоо, Дэмжлэг, Маркетинг сурталчилгаа

· ОУЗХ –ны гишүүнчлэл ба гишүүн бус байгууллагуудыг шинэчлэх, зохицуулах

· ОУЗХ- ны цахим сүлжээнд нэвтрэх дэлгэрэнгүй мэдээллийг нь бүх гишүүдэд өгөх

· Гишүүдийн хэрэгцээнд зориулсан номын сан байгуулах

· Арга хэмжээнүүдийг төлөвлөж, холбогдох бүртгэл хийх

· Дэмжлэг ба маркетинг

Хуудас 7

Элч нар

Элч нар бол ОУЗХ-ний гишүүдийн тусламжтайгаар улс орон бүрт ОУЗХ-ний сайн дурын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ОУЗХ-ны засаглалын стратегийн салшгүй нэг хэсэг нь юм. Улс орон бүр элчид нэр дэвшүүлэх, сонгох, томилох өөр өөр арга механизмтай байдаг. ОУЗХ-ны элч нар Олон Улсын Зуслангийн Холбооны хурал болох хугацаанд /гурван жил/ уг албыг хашдаг.

Их хурал хоорондын хугацаанд элч нар дараах үүрэг, хариуцлагыг хүлээдэг. Үүнд:

- ОУЗХ-ны удирдах зөвлөлийг төлөөлөн өөрийн орондоо ОУЗХ-ний хөдөлгөөнийг өрнүүлэх
- Өөрийн орондоо ОУЗХ-ны гишүүдийг цугларалтыг дэмжиж, хамт олон бий болгох
- Өөрийн орондоо ОУЗХ–ны гишүүдийг /жинхэнэ ба гишүүн бус байгууллагууд/ нэмж элсүүлэх.
- Үндэсний болон Олон Улсын хэмжээнд, зусланд амрагч хүүхдүүд болон зуслангийн багш нарын солилцоо хийх зэргээр гишүүдийн холбоо харилцааг хөгжүүлэх
- ОУЗХ-нд өөрийн орныхоо мэдээ мэдээллийг тогтмол хүргэх

- Өөрийн орны ОУЗХ-ны гишүүдэд олон улсын зуслан, ОУЗХ-ны хөтөлбөр, ОУЗХ-ны гишүүдэд зориулсан үйлчилгээний талаарх мэдээллийг түгээх
- ОУЗХ-ны удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, мэдээ мэдээлэл түгээх зэргээр Олон Улсын Зуслангийн Холбооны дараачийн их хуралд ОУЗХ-ны Ерөнхий ассемблейн гишүүнээр ажиллах
- Шаардлагатай бол өөрийн орны бүсийн зохицуулагчид дэмжлэг үзүүлэх
- Тохиромжтой гэж үзсэн өөр хэлбэрээр ОУЗХ-ны ажилд туслах.

Шинэ элч нарыг тогтмол сонгон авдаг. ОУЗХ нь 81 улсад өөрийн гишүүд, гишүүн бус дэмжигч байгууллагын тоог маш богинохон хугацаанд хурдацтай нэмэгдүүлсэн. ОУЗХ-ны зорилго бол одоогоор албан ёсны элч байхгүй улс орнуудад, хэрэв боломжтой бол элчийн хувиар ОУЗХ-г дэмжиж ажиллах зуслангийн ахлагч нарыг олж авах явдал юм. Асууж лавлах зүйл байвал jbradshaw@campingfellowship.org хаягаар ОУЗХ- ны Зөвлөлийн гишүүн/ ОУЗХ-ны зохицуулагч элч Жефф Брэдшоу – тай холбоо барина уу.

Эдгээр элч нар одоогоор элчийн үүргийг гүйцэтгэж байгаа. (2015 он 12 сар)

Хуудас 8

Олон улсын зуслангийн захирлуудын сургалт (ICDC)

ОУЗЗС хариуцсан зохицуулагч (АНУ) Конние Каутеллиер, ОУЗХ-ны Зөвлөлийн Андрей Макгукайн (Австрали) нар ОУЗХ-ны сургалтын хөтөлбөрийг хянаж, зохицуулдаг. Одоогоор таван идэвхтэй, мэргэжлийн гишүүдээс гадна арван оронд гучин таван сургагч, багш нар, туслах багш нар ажиллаж байна. Хэдийгээр Австрали, Өмнөд Америк зэрэг зарим оронд сургагч багш нар идэвхтэй сайн ажиллаж байгаа ч бусад бүсүүдэд сургагч багш нар дутагдалтай байна. Ялангуяа Хятад улсад болон англи хэлний боловсрол тааруу орнуудад энэ байдал илүү их ажиглагдана. 2016 онд Япон улсад болсон АНДЗХ- ны Их Хурлаас Захирлуудын сургалт болон сургагч багш нарын сургалтыг баталсан. 2016 оны сүүлээр буюу намар Канад, Австрали орнуудад Захирлуудын сургалт зохион байгуулагдана. Захирлуудын сургалт хариуцсан зохицуулагчид 2015 онд дараах сургалтуудыг явуулахаар сургагч багш нар, болон зохион байгуулах байгууллагуудтай хамтран ажиллалаа:

Хятад, 2015 оны 4 сар – 30 оролцогч

Конние Каутеллиер, Андрей Макгукайн, Теннант Киу (сургагч багш нар)

Австрали, 2015 оны 9 сар- 14 оролцогч

Паул Колагури (Ахлагч)

Мексик, 2015 оны 11 сар – 30 оролцогч

Симон Самбрано, Жуан Марио Гутирез (ахлагч нар) болон Бланка Жименез (туслах}

Сингапур улс 2015 оны 12 сар – 28 оролцогч

Теннант Киу, Андрей Макгукайн, Хэнк Яп (Сургагч багш нар).

Олон улсын зуслангийн холбооны хурал 2017

ОХУ, Сочи хотноо болох дараачийн олон улсын Зуслангийн холбооны хурлын бэлтгэл ажил хийгдэж байна. 4 сар, 10-р сард Шадар сайд Кагановтой хийсэн албан ёсны уулзалтуудын үр дүнд Оросын Боловсрол, Шинжлэх ухааны Яамны оролцоо, дэмжлэгийг албан ёсоор баталгаажуулжээ.

ОХУ-ын Зуслангийн Холбооны анхны ерөнхийлөгч, Орлёнок зуслангийн Гүйцэтгэх захирал

Александр Зевс 2017 онд болох ОУЗХ –ы Хурлын даргын үүрэг гүйцэтгэнэ. Оросын бусад зуслангийн удирдлагуудын дэмжлэгтэйгээр хурлын зохион байгуулалтын ажлын дийлэнхийг хариуцаж авахаа Орлёнок зуслан мэдэгдээд байгаа бөгөөд Жон Йоргенсен, Валери Костин, Жилл Дундас нар зохион байгуулалт ба төлөвлөлтийн хороодод өөр өөр үүрэг хариуцан ажиллаж байна.

Хурлын лого нь энх тайвны бэлэгдэл тагтаа шувууны хэлбэр бүхий Оросын уламжлалт хус модон тоглоомон шувууны дүрсээр илэрхийлсэн ICC хэмээх товчилсон үг юм. Хурлын сэдэв нь “дэлхийн бүх хүүхдүүдтэй аз жаргалыг хуваалцахуй” .

Хурлын үйл ажиллагааны маркетингийн төлөвлөгөөг 2016 оны хаврын улирлын эхэнд гаргах бөгөөд 2017 оны 10 сарын 15-19ны өдрүүдийг марталгүй санаж явахыг хүн бүхэнд уриалж байна. Нэг юм уу хоёр Захирлуудын сургалтын хөтөлбөр болон ОУЗХ-ны Удирдах зөвлөлийн хурлаар уг их хурлыг эхлэх бөгөөд дараа дараачийн арга хэмжээнд хурлын дараа Оросын зуслангийн удирдах ажилтнуудтай хамт уламжлалт аялал жуулчлалын газруудаар хийх аяллын хөтөлбөрүүдийг төлөвлөөд байна.

Хуудас 9

Судалгаа шинжилгээ

ОУЗХ-ны судалгаа шинжилгээний хороо дэлхийн зуслангийн салбарт хэрэгжүүлж буй судалгаа шинжилгээний ажлуудыг хянаж, зохих дэмжлэг үзүүлдэг.:

- ОУЗХ-ны судлаач, хамтран даргалагч Деб Биалешки, Стефен Файн нарын АЗХ-ны судлаач, туслах ажилтан Трой Беннеттэй хамтран гаргаж Роутлеж Олон Улсын Байгууллагад хэвлүүлсэн “Гадна орчны сургалтын гарын авлага” бүтээлийн *Зуслангийн туршлага: Гадна орчны сургалтаас суралцах нь* (2016) хэмээх бүлэгт голлох судалгаа, гадна орчны сургалтын судалгаа, шинэ санаа, өнөөгийн асуудал ба ирээдүйн хэтийн төлвийн талаар онцлон дурдах замаар зуслангийн туршлагын үнэ цэнийг илэрхийлэн гаргажээ.
- 2016 онд болох Ази Номхон далайн зуслангийн холбооны хурлын бэлтгэл ажил болгож Японы Үндэсний зуслангийн холбооноос Уриалга гаргажээ. Уг уриалгыг Япон орон даяар үйл ажиллагаа явуулж буй зуслангуудад тараах бөгөөд ОУЗХ-ны гишүүдээс хариу ирүүлсээр байна. Уг уриалгад Япон улс дахь зуслангийн үйл ажиллагааг танилцуулсан мэдээлэл Англи хэл дээр бичигдсэн байгаа.
- ОХУ-ын Новосибирскийн Улсын Багшийн Их Сургуулиас хийж буй судалгаа арай дуусаагүй байгаа.
- Клемсоны Их Сургуулиас ирэх ОУЗХ-ы судалгааны дүн мөн адил хүлээгдэж байна.
- Австралийн Гриффит Их Сургуулийн Аялал жуулчлал, спорт, зочид буудлын менежмэнтийн тэнхимийн докторант Мэнди Бейкерийн Канадын зуслангийн ажилчдын талаар хийж буй судалгааны ажил 2016 оны хавар гэхэд дуусна.

- Турк улсад одоо хэрэгжүүлж буй судалгааны төслүүд: Судлаач/ судалгааны ажлын удирдагч: Доктор Мубера Селеби. Турк дахь судалгааны төслүүдийг Абант Иззет Бейсел Их Сургууль дээр Судалгааны төслийн баг хэрэгжүүлж байна. Төслийн багийн гишүүд: Доктор Мелия Аталей Нүрдеграф, Доктор Бураз Гурер, Дозтор Зухал Килинк, Доктор Мелике Эсентас, Доктор Селхан Озбей, Доктор Пинар Гузел, Доктор Есэр Эскоглу, Доктор Хули Унлу, Эртан Табук. *Хүүхэд залуучуудын зуслангийн үйл ажиллагаанд оролцож буй эмэгтэй оюутнуудын манлайлах ухамсар ба чадварыг хөгжүүлэх нь*; Залуучууд ба спор зуслангийн ээлжийн үеэр хийсэн кейс судалгаа, судлаач: Доктор Мелике Эсэнтас, PhD. Эрдмийн ажил, 2015, Селал Бейер Их Сургууль.

  Судалгаа нэг: Энэхүү судалгааны зорилго нь удирдлагын түвшинд залуучуудын зуслангийн үйл ажиллагааг судлах, Турк улсын нөхцөл байдалд тохирсон загварыг санал болгоход оршино.

Судалгаа хоёр: Зорилго: 2016-2018 онд хэрэгжүүлэх зуслангийн сайн дурынхны манлайлах чадварыг хөгжүүлэх ба сайн дурын сургалтын төсөл: Зуслангуудын удирдлагын бүтцийг судалж, харьцуулах (Турк, АНУ, ОХУ, Канад, Европ, Австри улсын жишээн дээр)

- "2016 Америкийн Зуслангийн Холбооны зуслангийн судалгааны бүтээлийн хураангуй" - ийг цахим холбоос байдлаар ОУЗХ-ы цахим хуудсанд байршуулж, түгээх.

Судалгааны жагсаалт: Энэхүү жагсаалт нь залуусын хөгжил ба зуслангийн үйл ажиллагаатай холбоотой судалгаа, үнэлгээ хийхийг сонирхож буй бүхий л мэргэжилтнүүдэд нээлттэй. Хүсэлтээ: *dbialeschki@acacamps.org хаягаар ирүүлж болно.*

Дараа дараачийн эрдэм шинжилгээний хурлууд, хэрэгжүүлэх төслүүд болон цахимд суурилсан судалгаа, үнэлгээний эх үүсвэр ба зуслангийн мэргэжилтнүүдэд өгөх мэдээлэл зэрэг асуудлаар хийх хэлэлцүүлэгт Судалгааны Хороо оролцох болно.

Хуудас 10

Билл Боукерийн сургалтын тэтгэлэгийн сан

Олон улсын зуслангийн холбоотой урт удаан хугацааны хамтын ажиллагаа, нөхөрлөлийн дурсгалд зориулан байгуулагдсан энэхүү сан нь ОУЗХ –ны гишүүдийг Олон улсын зуслангуудын их хурал болон бусад ач холбогдол бүхий мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрүүдэд хамрагдах, оролцоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэ санг албан ёсны зуслангийн холбоо байгуулах дэмжлэг, нөөц бололцоо байхгүй орны өргөдөл гаргагчдад зориулан, зохион байгуулалттай зуслангийн хөтөлбөр, холбоодыг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулсан.

Шагналууд

Хамба лам Фенн Дружбагийн нэрэмжит шагнал бол ОУЗХ-ны дээд шагнал юм. Энэ нь олон улсын зуслангуудын үйл ажиллагаа, хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан хувь хүн, зуслан, байгууллагад тусгайлан олгодог шагнал билээ.

Эрвээхэй шагналыг урт хугацааны туршид зуслангийн үйл ажиллагаанд /байгаль орчин, хүмүүнлэгийн болон боловсролын чиглэлээр/ олон улсын түвшинд томоохон хувь нэмэр оруулсан хувь хүн, зуслан, байгууллагад олгодог.

Гавъяаны хүндэт өргөмжлөлийг дэлхийн зуслангийн салбартай холбоотой тодорхой төслүүдэд үлгэж жишээч ажил гүйцэтгэсэн хувь хүн, байгууллагуудад олгодог.

Нэр дэвшүүлэх маягт болон тавигдах шалгууруудыг ОУЗХ-ны веб хуудсанд байршлуулсан байдаг.

Тусгай хөтөлбөрүүд болон бага хурал

Америкийн Нэгдсэн Улс: Жил бүр, Америкийн Зуслангуудын Холбооны жил бүрийн Үндэсний бага хурлаас өмнө, ОУЗХ –оос орон нутгийн зуслангуудын аялал, олон улсын зочдод зориулсан байгалийн аялалын хөтөлбөр, бусад зуслангийн мэргэжилтнүүдийг уулзаж, сүлжээгээ тэлэх боломжийг олгох залуучуудын үйл ажиллагааг дэмжсэн үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулдаг. 2015 онд, 23 оролцогчдод зориулсан аяллыг Зүүн Луизана дахь Охидын Скаутуудтай хамтран Линда Пуллиам, Гвинн Поувел нар зохион байгууллаа. Аяллын багийнхан Шинэ Орлеан дахь зуслангуудад очиж, хөтөлбөрүүдэй танилцав. Жим Кэйн танилцах аялалын салхийг хагалсан хүн болов.

Монгол улс: 2015 оны 5 сард Улаанбаатар хотын Хүүхэд залуучуудын Найрамдал төвд зуслангийн зөвлөхүүд, арга зүйч, багш нарт зориулсан “Дэлхийн улс үндэстнүүдийн тоглоомууд” сэдэвт олон улсын сургалт семинарыг Жим Кейн удирдан явуулав. Уг арга хэмжээнд Орос, Хятад, Камерун, Канад, Австрали, АНУ- ийн төлөөлөгчид оролцлоо.

Холбооны Ерөнхийлөгч, Гүйцэтгэх Захиралуудын Хурал (М.А.Р.Е.)

Олон улсын зуслангуудын холбооны хурлын үеэр үндэсний болон бүсийн холбоодын ерөнхийлөгчид, гүйцэтгэх захирлуудад мэдээлэл өгөх хурлыг зохион байгуулдаг. Хурал хоорондын завсрын хугацаанд Холбооны Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлуудын хурлын гишүүдэд холбогдох мэдээллийг илгээдэг. Мексикийн Зуслангуудын Холбооны Ерөнхийлөгч Паблос Касас судалгаа болон шууд харилцааны хэлбэрээр Хурлын бүх гишүүдтэй холбогдсон. Дараачийн ээлжит хурал ОХУ-ын Сочи хотноо болох 2017 оны ОУЗХ-ны хурлын үеэр зохион байгуулагдана.

Хуудас 11

Ази Номхон Далайн Зуслангуудын Холбоо

Ази Номхон Далайн Зуслангуудын Холбоо (АНДЗХ) нь дэлхийн тодорхой бүсүүдээс гаралтай ОУЗХ-ны гишүүдээс бүрдэнэ. Турк, Орос, Номхон далайн орнууд, Австрали зэрэг Азийн гишүүн орнуудаас гаралтай ОУЗХ –ны гишүүдийг уг холбооны гишүүд гэж үзнэ. Одоогоор АНДЗХ-ы бүх гишүүдийг ОУЗХ-ны гишүүд гэж үздэг. 2003 онд Австрали улсын Мелбурни хотноо болсон Олон улсын зуслангийн холбооны 6-р хурлаар АНДЗХ - ийг байгуулсан. Уг холбоог Ази тивд нэгэн ашиг сонирхлын хүрээнд зуслангуудыг нэгтгэх, Азийн бүс нутагт зусланг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулсан. АНДЗХ- ийн үндсэн үйл ажиллагаа нь гурван жил тутамд болдог (Олон улсын зуслангуудын холбооны хурлаас нэг жилийн өмнө) Ази Номхон Далайн Зуслангуудын Холбооны хурлыг дэмжин ажиллахад чиглэдэг. Зуслангийн мэргэжилтнүүд, дэмжигч нарыг бүс нутаг үл хамааран хэдийд ч хүлээн авдаг бөгөөд холбооноос зохион байгуулсан соёлын болон мэргэжлийн арга хэмжээнүүдэд хүн бүр хамрагдах боломжтой. АНДЗХ нь олон улсын чанартай үйл ажиллагааг ивээн тэтгэдэг бөгөөд үүний нэг жишээ нь 2015 оны 5-р сард Олон улсын хүүхдийн Найрамдал төвөөс зохион байгуулах Дэлхийн улс үндэстний тоглоомууд сэдэвтэй Олон улсын сургалт юм. АНДЗХ болон түүний үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл АНДЗХ-ны дарга, ОУЗХ-ны Удирдах Зөвлөлийн гишүүн Билл Оаклэй (Австрали)-тэй холбоо барина уу

Ази Номхон Далайн Зуслангуудын Холбооны 6-р хурал

2000 онд Япон улсын Токио хотноо Олон улсын Зуслангийн 5-р хурал болсон. 2016 онд, олон улсын зуслангийн салбарынхан Ази Номхон Далайн Зуслангийн холбоогы 6-р хуралд оролцохоор 10 сарын 28-наас 11 сарын 1-ний хугацаанд Токио хотноо хуран цугларах юм. Уг хурал зохион байгуулалттай зуслангийн үйл ажиллагааны хүрээнд залуусын хөгжилд онцгой хувь нэмэр оруулах зорилго бүхий хөтөлбөрүүдтэйгээр “Сайн сайхан нийгмийн төлөөх зуслан” гэсэн уриан дор зохион байгуулагдана. Хурал 1964 оны Олимпийн наадам болсон хуучин Хөнгөн атлетикийн тамирчдын хүрээнд буюу Токио хотын Үндэсний Залуучуудын Төвд болох юм. Энэ жил 2016 онд Японы Үндэсний Зуслангийн Холбоо үүсгэн байгуулагдсаны 50 жилийн ой тохиож байгаа бөгөөд Хурал дээр холбооны 50 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэгдэх юм. Үүнээс гадна уг тайланд 2012 онд хойд Хоншу мужид болсон аймшигт газар хөдлөлт, цунамид нэрвэгдсэн олон олон хүүхдүүдэд туслах “Гамшгийн дараах сэтгэл заслын зуслангууд”-ыг нээж, ажиллуулахтай холбоотой амаргүй үйл явцыг ч тусгажээ. Хятад болон Зүүн Азид орших зохион байгуулалттай зуслангуудыг хөгжлийг дэмжих зорилгоор хурлын өмнө Олон улсын зуслангуудын захирлуудын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хуудас 12

2015 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан

Хуудас 13

2015 оны жилийн эцсийн тайлан

Хуудас 14

ОУЗХ –НЫ ЗАСАГЛАЛ

Хуудас 15

ОУЗХ-НЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ - 2014-2017

ОУЗХ-ны үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл авах бол www.campingfellowship.org веб хуудсанд зочилно уу.

ОУЗХ-ны ажилд оролцох идэвхтэй сайн дурын гишүүн болохыг хүсвэл, бидэнтэй дараах хаягаар холбогдоно уу: volunteer@campingfellowship.org